



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/71/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.8.2	Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	байхгүй	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.12 № 2/01

танай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ

C:\Users\Dell\Desktop\2019 on gerchilgee\Aimgiin EMGazar.docx

2518463

болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга В.Нарантуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.10-наас 2019.01.16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.12-ны өдөр 2019.01.04-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь “Нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгон ёс зүй, хариуцлагыг дээдлэн, нөөцийг оновчтой, үр дүн, үр ашигтай ашиглаж хүн амд чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд ард иргэдэд эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих сургалт сурталчилгааг эрчимжүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс

үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 40 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашиглаж, цалингийн тооцооллыг “Payroll 2018” цалингийн программ ашиглан гүйцэтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, гүйцэтгэлийн шатанд 1эрсдэл нэмж тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2018873,9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 20188,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5958.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	5958,0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2 Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал

Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн улирал бүр ажилтнуудын ажлыг дүгнэж урамшуулал олгосон атлаа 12-р сард Баянхонгор аймгийн ЭМГ-ын даргын 2018.12.14-А/96 тоот тушаалаар ажилтнуудад жилийн эцсийн ажлын гүйцэтгэлээр 5958,0 мянган төгрөгийн урамшуулалыг цалингийн зардлаас давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна..

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд улсын төсвөөс 1822077,2 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 1808899,7 мянган төгрөгийг зарцуулж 13177.5 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн НДХ-ээс ХЧТАТэтгэмжид 10327,2 мянган төгрөг, төсөл хөтөлбөрийн санхүүжилт бусад орлогоор 213059,8 мянган төгрөг төвлөрснийг зарцуулан, үлдэгдэл 30600,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж санхүүгийн тайланд санхүүжилтийн авлага, байгууллагад төлөх өглөгөөр тусгасан байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллийг хугацаанд нь, нийт шилэн дансанд 147 мэдээлэл байршуулснаас 6 хоцроосон байна. Хуулийн 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 88 гүйлгээ байгааг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд 3 заалт бүхий зөвлөмж өгснийг 2018.04.16-ны 220 тоот албан бичгээр хариу ирүүлсэн ба хэрэгжилт гүйцэтгэлээр 80 хувьтай байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Аймгийн Эрүүл мэндийн газар нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

Аудитаар цалингийн зардлыг бүлэг дотор нь авч үзэхэд унаа болон бусад нөхөн олговорт 10.4 сая төгрөг батлагдсан байхад гүйцэтгэлээр 49.0 сая төгрөг олгож цалингийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Төсөвт нэр төрлөөр батлагдсаны дагуу хоол, урамшуулалын зардлыг олгож, Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3.1.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,700,120.78	73,643,312.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,000,000.00
3121	Төгрөг	00.00	2,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,000,000.00
33	АВЛАГА	25,721,670.93	30,600,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,641,521.00	30,600,000.00
335	Бусад авлага	13,080,149.93	00.00
3351	Байгууллагаас авах авлага	10,081,149.93	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,999,000.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	600,000.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	600,000.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	600,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,378,449.85	41,043,312.85
351	Түүхий эд материал	24,498,099.10	30,116,299.10
35110	Тусгай зориулалттай материал	18,216,704.10	24,354,704.10
35130	Эм боох материал	6,281,395.00	5,761,595.00
354	Хангамжийн материал	4,880,350.75	10,927,013.75

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35410	Бичиг хэргийн материал	1,390,800.00	2,417,563.00
35420	Аж ахуйн материал	2,281,120.00	7,211,020.00
35450	Барилгын засварын материал	456,300.00	546,300.00
35470	Бусад хангамжийн материал	752,130.75	752,130.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>694,443,325.69</u>	<u>1,221,629,571.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	694,443,325.69	1,221,629,571.72
392	Биет хөрөнгө	694,402,075.69	1,059,054,571.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	837,584,444.00	817,245,798.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-259,702,635.19	-355,099.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,771,297.00	156,821,297.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	-74,771,297.00	-85,051,297.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,656,397.87	159,975,345.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,791,969.05	-104,720,700.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,210,074.66	201,923,080.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,138,763.48	-87,454,852.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,779,263.00	1,042,350.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,194,736.12	-371,350.00
393	Биет бус хөрөнгө	41,250.00	162,575,000.00
39301	Програм хангамж	1,364,000.00	1,364,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,322,750.00	-1,364,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	200,000.00	162,775,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>750,143,446.47</u>	<u>1,295,272,884.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>196,150.56</u>	<u>30,802,983.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	196,150.56	30,802,983.00
413	Өглөг	196,150.56	30,802,983.00
4136	Бусад өглөг	00.00	30,802,983.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	30,600,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	202,983.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>749,947,295.91</u>	<u>1,264,469,901.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	749,947,295.91	1,264,469,901.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	592,571,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	592,571,079.04	755,146,079.04
512	Хуримтлагдсан үр дүн	-343,360,586.13	-246,864,986.42
51210	Өмнөх үеийн үр дүн	-343,360,586.13	-343,360,586.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,495,599.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	500,736,803.00	756,188,808.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>750,143,446.47</u>	<u>1,295,272,884.57</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

төгрөг

БНА-2019/71/СТА-ТШЗ

14

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,797,010,454.00	2105042317,67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	82,546,833.41
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	52,846,833.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	52,846,833.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	161,593.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	52,685,240.08
122	Тусламжийн орлого	00.00	29,700,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	29,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,797,010,454.00	2022495484,26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,614,264,000.00	1,822,077,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,614,264,000.00	1,822,077,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,850,801.00	200,418,284.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	104,433,244.26
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,063,544.00	9,383,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,219,257.00	84,788,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,568,000.00	1,814,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,895,653.00	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,895,653.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,823,429,023.05	2000970506,18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,823,429,023.05	2000970506,18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,812,695.05	900,885,889.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,100,402.34	434,349,200.70
210101	Үндсэн цалин	406,100,402.34	434,349,200.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,915,008.26	51,776,711.00
210201	Тэтгэврийн даатгал	28,814,688.47	35,210,921.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,852,889.10	4,343,765.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,951.07	3,475,012.68
210204	Ажилгүйдлийн даатгал	721,134.42	795,182.07
210205	Эрүүл мэндийн даатгал	7,211,345.20	7,951,828.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,054,950.00	77,978,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,326,957.00	4,889,126.00
210302	Түлш, халаалт	55,187,129.00	57,593,250.00
210303	Цэвэр, бохир ус	15,540,864.00	15,495,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,543,192.00	27,612,402.00
210401	Бичиг хэрэг	4,360,560.00	3,781,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,019,330.00	19,381,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,229,022.00	1,398,253.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	471,600.00	131,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,462,680.00	2,920,639.00
2105	Нормативт зардал	2,141,380.00	5,497,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,118,380.00	5,497,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,860,461.00	17,458,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,000.00	84,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	00.00
210604	Урсгал засвар	21,715,461.00	17,373,750.00
2107	Томилолт, зочны зардал	8,033,200.00	11,026,500.00
210702	Дотоод албан томилолт	8,033,200.00	11,026,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,271,081.03	200,199,677.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,584,381.03	192,021,089.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	380,000.00	381,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	415,800.00	645,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	475,200.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,300.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,295,000.00	6,521,000.00
210807	Газрын төлбөр	59,400.00	51,888.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ	25,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,893,020.42	74,986,848.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,496,300.00	16,496,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,627,000.00	995,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,769,720.42	57,495,548.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,004,616,328.00	1100084617
2132	Бусад урсгал шилжүүлэг	906,947,280.00	1100084617
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,895,653.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	277,484,680.00	327,842,683.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	614,673,268.00	726,614,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,893,679.00	1,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,669,048.00	43,777,516.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,669,048.00	43,777,516.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,418,569.05	104,071,811.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,138,061.14	7,576,211.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,138,061.14	4,552,434.98
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	3,023,776.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,138,061.14	-7,576,211.78
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,556,630.19	96,495,599.71

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,797,010,454.00	2037137005,26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,797,010,454.00	2037137005,26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,614,264,000.00	1,822,077,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,614,264,000.00	1,822,077,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,850,801.00	215,059,805.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	116,228,765.26
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,063,544.00	9,383,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,219,257.00	85,634,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,568,000.00	3,814,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,895,653.00	10,327,205.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,895,653.00	10,327,205.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,787,038,115.00	1942956005,26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,787,038,115.00	1942956005,26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	782,421,787.00	843,074,371.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,942,933.00	435,749,199.00
210101	Үндсэн цалин	404,942,933.00	435,749,199.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,958,002.00	51,571,629.00
210201	Тэтгэврийн даатгал	43,958,002.00	51,571,629.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,054,950.00	77,978,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,326,957.00	4,889,126.00
210302	Түлш, халаалт	55,187,129.00	57,593,250.00
210303	Цэвэр, бохир ус	15,540,864.00	15,495,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,417,961.00	28,911,550.00
210401	Бичиг хэрэг	3,608,360.00	4,477,247.00
210402	Тээвэр, шатахуун	19,032,700.00	19,032,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,229,022.00	1,416,253.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	534,600.00	131,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,013,279.00	3,854,350.00
2105	Нормативт зардал	7,670,600.00	4,886,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,627,600.00	4,558,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,043,000.00	328,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,452,461.00	24,366,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	461,000.00	1,744,800.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210602	Тавилга	00.00	429,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	792,000.00
210604	Урсгал засвар	19,991,461.00	21,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,033,200.00	11,026,500.00
210702	Дотоод албан томилолт	8,033,200.00	11,026,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,768,380.00	191,093,393.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,584,380.00	182,459,805.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	380,000.00	381,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	415,800.00	645,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	475,200.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,300.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,792,300.00	6,976,000.00
210807	Газрын төлбөр	59,400.00	51,888.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,123,300.00	17,491,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,496,300.00	16,496,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,627,000.00	995,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,004,616,328.00	1099881634.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	906,947,280.00	1056104118.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,895,653.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	277,484,680.00	327,639,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	614,673,268.00	726,614,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,893,679.00	1,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,669,048.00	43,777,516.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,669,048.00	43,777,516.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,972,339.00	94,181,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,972,339.00	92,181,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,972,339.00	92,181,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,972,339.00	92,181,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,972,339.00	92,181,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,972,339.00	-92,181,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,000,000.00

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
СТ-4А

төгрөг

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	592,571,079.04	500,736,803.00	-343,360,586.13	749,947,295.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	592,571,079.04	500,736,803.00	-343,360,586.13	749,947,295.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	255,452,005.95	00.00	255,452,005.95
D08	Тайлант үеийн үр дүн	162,575,000.00	00.00	96,495,599.71	259,070,599.71
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,680,184,000.00	1,529,241,473.00	1,822,077,200.00	1,808,899,684.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,680,184,000.00	1,529,241,473.00	1,822,077,200.00	1,808,899,684.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626,971,800.00	624,189,846.00	759,640,700.00	752,795,566.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,947,600.00	404,942,933.00	435,749,200.00	435,749,199.00
210101	Үндсэн цалин	246,636,600.00	404,942,933.00	325,190,400.00	435,749,199.00
210102	Нэмэгдэл	132,436,700.00	00.00	78,918,700.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,227,200.00	00.00	10,415,700.00	00.00
210104	Урамшуулал	20,647,100.00	00.00	21,224,400.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,574,000.00	43,958,002.00	52,289,900.00	51,571,629.00
210201	Тэтгэврийн даатгал	29,638,000.00	43,958,002.00	34,859,900.00	51,571,629.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,234,000.00	00.00	4,357,500.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,387,200.00	00.00	3,486,000.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	846,800.00	00.00	871,500.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,468,000.00	00.00	8,715,000.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,086,200.00	75,054,950.00	77,978,200.00	77,978,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,358,300.00	4,326,957.00	4,888,800.00	4,889,126.00
210302	Түлш, халаалт	55,187,100.00	55,187,129.00	57,594,100.00	57,593,250.00
210303	Цэвэр, бохир ус	15,540,800.00	15,540,864.00	15,495,300.00	15,495,824.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,474,100.00	29,417,961.00	29,024,100.00	28,911,550.00
210401	Бичиг хэрэг	3,610,200.00	3,608,360.00	4,110,200.00	4,477,247.00
210402	Тээвэр, шатахуун	19,032,700.00	19,032,700.00	19,032,700.00	19,032,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,283,300.00	1,229,022.00	1,783,300.00	1,416,253.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	534,600.00	534,600.00	534,600.00	131,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,013,300.00	5,013,279.00	3,563,300.00	3,854,350.00
2105	Нормативт зардал	7,670,600.00	7,670,600.00	4,892,600.00	4,886,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,627,600.00	4,627,600.00	4,558,200.00	4,558,200.00
210502	Хоол, хүнс			00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,043,000.00	3,043,000.00	334,400.00	328,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,804,900.00	28,804,900.00	121,244,800.00	116,547,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,729,300.00	8,813,439.00	17,122,800.00	17,122,800.00
210602	Тавилга			81,690,000.00	76,992,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00	1,032,000.00	1,032,000.00
210604	Урсгал засвар	20,075,600.00	19,991,461.00	21,400,000.00	21,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,034,600.00	8,033,200.00	11,034,600.00	11,026,500.00
210702	Дотоод албан томилолт	8,034,600.00	8,033,200.00	11,034,600.00	11,026,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,256,500.00	8,184,000.00	8,839,700.00	8,633,588.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	381,100.00	380,000.00	381,100.00	381,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	415,800.00	415,800.00	645,600.00	645,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	475,200.00	475,200.00	480,000.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	36,300.00	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,801,000.00	6,792,300.00	7,174,000.00	6,976,000.00
210807	Газрын төлбөр	59,400.00	59,400.00	60,000.00	51,888.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,000.00	25,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,123,300.00	18,123,300.00	18587600.00	17491300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,496,300.00	13,496,300.00	16,496,300.00	16,496,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,627,000.00	4,627,000.00	2,091,300.00	995,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,053,212,200.00	905,051,627.00	1062436500.00	1056104118.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,053,212,200.00	905,051,627.00	1,062,436,500.00	1,056,104,118.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	369,879,700.00	277,484,680.00	327,639,700.00	327,639,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	637,357,500.00	614,673,268.00	732,946,800.00	726,614,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,975,000.00	12,893,679.00	1,850,000.00	1,850,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,680,184,000.00	1,529,241,473.00	1,822,077,200.00	1,808,899,684.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,680,184,000.00	1,529,241,473.00	1,822,077,200.00	1,808,899,684.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,680,184,000.00	1,529,241,473.00	1,822,077,200.00	1,808,899,684.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	44	47	44
620001	Удирдах ажилтан	3	4	4	5
620002	Гүйцэтгэх ажилтан	34	31	33	29
620003	Үйлчлэх ажилтан	10	9	10	10
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	44	47	44
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17	16	17	29
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	10	11	10	2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20	17	20	13